



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.03.18 № 01/3817.
танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Авлигыг үл тэвчих талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр иргэд, олон нийтийн санаа бодлыг сонсох, тэдгээртэй хамтран ажиллах, холбогдох мэдээ, мэдээллийг иргэдэд цаг алдалгүй хүргэх нь авлига, ашиг сонирхлын зөрлөөс урьдчилан сэргийлэхэд нэн чухал билээ.

Мэдээллийн технологи хурдацтай хөгжихийн хэрээр цахим орчинд ажиллах иргэдийн чадавх нэмэгдэж, нийгмийн сүлжээн дэх тодорхой нэр, хаяг бүхий бүлэг, бүлгэмүүдэд нэгдэж, идэвхтэй хандалт хийн түүгээр дамжуулан шаардлагатай мэдээ, мэдээллийг олж авах, санаа бодлоо илэрхийлэх, улмаар сайн дурын шинжтэй, нийгэмд ач холбогдол бүхий аян, чөлөнхийг өрнүүлэх болсон.

Дэлхийн улс орнууд НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргасан “Таны эрх, Таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” уриан дор нэгдэж, авлигатай тэмцэх хүсэл зоригоо илэрхийлэх, хамтран ажиллах боломжийг олон нийтэд олгох чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байна. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газраас “Зөв зөвд шударга зөв” аяныг улсын хэмжээнд зохион байгуулж байгаа бөгөөд олон нийтийн сүлжээг ашиглан авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах, үнэн зөв мэдээ, мэдээллийг бодит эх сурвалжаас түгээх зорилготой “Авлигатай тэмцэх газар” пэйж хуудас, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, ёс зүйг дээшлүүлэх, байгууллагын соёлыг тогтоох зорилготой “АТГ-Олон нийтийн төв” фэйсбүүк пейж хуудсыг тус тус хөтлөн ажиллуулж, мэдээ, мэдээллийг олон нийтэд тасралтгүй хүргэсээр байна.


Цаашид энэхүү арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулж, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, уг үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх ба мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бүх шатны төрийн албан хаагчдын үүрэг, оролцоо чухал байх тул авлигатай тэмцэхэд манлайлан оролцож, манай байгууллагын дээр дурдсан хоёр пэйж хуудсыг байгууллагынхаа нийт албан хаагч, бие бүрэлдэхүүнд сурталчлах, нэгдэх, дагах ажлыг зохион байгуулан хамтран ажиллахыг Танаас хүсье.

Дээрх үйл ажиллагааны үр дүн танай байгууллагаас батлан хэрэгжүүлж буй “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” болон байгууллагын шударга байдлын үнэлгээ (Шударга байдлын үнэлгээ 2022)-ний нэг үзүүлэлт болох юм.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА



142203006073



АТГ - Олон Нийтийн Төв
хуудсанд.....
хаягнаас нэгдэв



110

Гомдол, мэдээлэл
хүлээн авах утас



Авлигатай Тэмцэх Газар
хуудсанд.....
хаягнаас нэгдэв



110

Гомдол, мэдээлэл
хүлээн авах утас